



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/198

Мандалговь

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1,2,4 дэх заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Их тойруу-7 гудамж, 724 тоот)-д байршилтай Дагдан овогтой Очбадрах (ЗП:84071412)-ын үйлчилгээний зориулалттай 1200 м.кв (0,12 га) газрыг иргэн Гаваа овогтой Энхжаргал (ЗК:77032409)-д зориулалтаар нь шилжүүлж 12 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн А/332 дугаар захирамжийн Д.Очбадрах-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000712352 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

488190511